



**“БУЛИГААР” ХК-ИЙН САНХҮҮГИЙН ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 2/			
<i>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</i>			
Тайлагнах хугацаа	2025 оны 01 дугаар сарын 01-ний өдрөөс 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр		
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	“Булигаар” ХК УБГД: 9010001072, РД:2039184 MSE: MBG Утас: 99110026		
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж		
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Гутлын дээд биеийн материал үйлдвэрлэх Арьс шир боловсруулалт Худалдаа Худалдааны зуучлал Гадаад худалдаа		
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	400,212,000		
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: Ерөнхий нягтлан бодогч Г.Сэлэнгэ ТУЗ-ийн гишүүн Ц.Мөнхлхагва Хянасан: Гүйцэтгэх захирал Б.Баттүшиг		
1.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан <i>/хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</i>		
Санхүүгийн байдлын үзүүлэлт	Эргэлтийн хөрөнгийн дүн:		15 937 197 257.84
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн:		18,247 864 245.13
	Нийт хөрөнгийн дүн:		34 185 061 502.97
	Өр төлбөрийн нийт дүн:		23 073 959 586.22
	Эздийн өмчийн дүн:		11 111 101 916.75
	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн:		34 185 061 502.97

	Орлогын тайлан	Борлуулалтын орлого:	1 802 226 806.16
		Борлуулсан бүтээгдэхүүний өртөг:	1 526 764 050.83
		Нийт ашиг:	
		Түрээсийн орлого	1,023,000
		Хүүний орлого	0,00
		Бусад орлого:	0,00
		Борлуулалт маркетингийн зардал	36 698 969.75
		Ерөнхий удирдлагын зардал	92 738 654.39
		Бусад зардал:	105 657.56
		Гадаад валютын ханшийн зөрүүний олз гарз	0.00
		Татвар төлөхийн өмнөх ашиг:	150 942 473.63
		Орлогын татварын зардал:	15 104 813.12
		Тайлант үеийн цэвэр ашиг:	135 837 660.51
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	2023 оны 12 сарын 31-ны үлдэгдэл:	13 654 412 648.45
		2024 оны 12 сарын 31-ны үлдэгдэл:	12 966 912 712.75
		2025 оны тайлант үеийн цэвэр ашиг:	135 837 660.51
	Мөнгөн гүйлгээний тайлан		
		Мөнгөн орлогын дүн:	1 517 235 118
		Мөнгөн зарлагын дүн:	1 932 795 190.84
		Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн:	415 560 072.84
		Мөнгөн орлогын дүн	500 000 000.00
		Мөнгөн зарлагын дүн	103 935 527.11
		Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00
		Мөнгөн орлогын дүн	500 000 000.00
		Мөнгөн зарлагын дүн:	103 935 527.11
		Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	396 064 472.89
		Валютын ханшийн зөрүү	0.00
		Цэвэр мөнгөн гүйлгээ:	-19 495 599.95
		Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14 182 297.87
		Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл :	-5 313 302.08
2.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт		
	Тус компанийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шинээр сонгогдох Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар компанийн 2025 оны 01 дүгээр улирлын тайланг хэлэлцэх бөгөөд 1 дүгээр улирлын тайланг холбогдох журмын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, МХБ-д хүргүүлэхийг даалгасан байгаа.		

3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт		
3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Санхүүгийн үзүүлэлтүүд Ашигт ажиллагаа	
3.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Нийт хөрөнгийн өгөөж (ROA)	0.05%
		Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE)	0.05%
		Өөрчлөлтийн хувь /оны эхнээс/	
		Нийт активын өөрчлөлт	0.05%
		Зээлийн багцын өөрчлөлт	1.01%
		Хөрөнгөд эзлэх хувь	
		Өөрийн хөрөнгө /Нийт хөрөнгө/	0.11%
		Өр төлбөр /Нийт хөрөнгө/	0.33%
		Хөрвөх чадварын харьцаа	
		Хөрвөх чадварын хөрөнгө/	0.13%
		Татан төвлөрүүлсэн хөрөнгө	0.97%
3.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	2025 оны 1-р улирлын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад борлуулалт 0.01%-иар буурсан байна. Өмнөх оны мөн үеэс өсөөгүй нь дотоодын зах зээлд бүтээгдэхүүний үнийн бодлогыг шинэчлэн тогтоосонтой холбоотой байх магадлалтай. • Арьс ширний үйлдвэрүүдийг шинэ суурьшлын бүс болох эмээлт рүү нүүлгэх төрийн бодлогын чиглэл хандлага тодорхой болсон. • Ижил төрлийн бүтээгдэхүүний хяналтгүй импортын эсрэг үйлдвэрлэлийн технологийг тогтвортой байлгах, шинэчлэлт хийх бодлого барьж ажиллаж байгаа. • Мэргэжлийн болон менежментийн ур чадвар бүхий ажиллах хүчний тасалдал бий болсон төдийгүй энэ байдал цаашид үргэлжлэх хандлагатай байна. Энэхүү асуудал нь салбар төдийгүй улсын хэмжээнд яригдах болсон.	
3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл	Санхүүгийн тайлангаас гадуурх бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй болно.	

4.	<i>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</i>
	2024.12.31-ний өдрийн байдлаар Капитрон банкнаас авсан зээлийн барьцаанд компанийн үл хөдлөх хөрөнгө болон газрыг тус тус барьцаасан байгаа. Зээлийн эргэн төлөлт хэвийн явагдаж байгаа болно. Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй болно.
5.	<i>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл</i>
	Тайлант хугацаанд олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй болно.
6.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл
	ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр ажиллав. Үүнд: ▪ Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр: Ж.Эрдэнэбат, Т.Болд, Ч.Нямдорж ▪ Төлөөлөн Удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр: Б.Анхболд, А.Энхмэнд, Б.Баянжаргал, Д.Гансүх, Б.Баттүшиг, Ц.Мөнхлхагва “Булигаар” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуулийн хүрээнд Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах, тэднийг төлөөлж компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар ханган, компанийн стратегийн зорилтот түвшин, санхүү эдийн засгийн үзүүлэлт, бизнес төлөвлөгөөг батлан, холбогдох чиг үүрэг, зөвлөмжүүдийг өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллав. Дэргэдээ байнгын үйл ажиллагаатай Цалин урамшууллын хороо, Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороог ажиллуулж, засаглалын болон дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан. 2024.04.19-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТУЗ-ийн 9 гишүүн 1 жилийн хугацаатайгаар сонгогдсон бөгөөд 2025.04.18-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудал хэлэлцэгдэх болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаан, ирц: ТУЗ-ийн дэргэд 3 хороо үйл ажиллагаа явуулдаг бөгөөд ТУЗ-ийн ээлжит хурал улирал тутам, хороод жилд 2 удаа ээлжит хурлаа зохион байгуулан компанийн тайлан мэдээлэлтэй танилцаж, ТУЗ-ийн зүгээс компанийн удирдлагуудад санал, зөвлөмж, үүрэг даалгавар өгч ажилладаг. Төлөөлөн удирдах зөвлөл нь 100 хувийн ирцтэйгээр 4 удаагийн хуралдаанаар 5 тогтоолоор шийдвэр гарган, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан байна. ТУЗ-ийн хурлыг танхимаар, цахимаар, эчнээгээр зохион байгууллаа.

ТУЗ-ӨӨС ШИЙДВЭРЛЭСЭН ТОГТООЛЫН АГУУЛГА						
№	Хуралдсан огноо	Тогтоолын дугаар		Тогтоолын тухай		
1	2025.01.10	01/25	Эрх олгох тухай			
		02/25	Эрх олгох тухай			
2	2025.02.17	03/25	Ногдол ашгийн тухай			
3	2025.02.24	04/25	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай			
4	2025.03.18	05/25	Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд дүгнэлт өгөх тухай			
ТУЗ БОЛОН ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН ХУРАЛДААН						
Хурал	Ээлжит хурал	Ээлжит бус хурал	Хэлэлцсэн асуудал	Шийдвэр	Санал зөвлөмж	Баталсан тогтоол
ТУЗ-ийн хурал	3	1	5			5
Аудитын хороо	2	1	4	3	1	3
Цалин урамшууллын хороо						
Нэр дэвшүүлэх хороо						
ХУРЛЫН ИРЦ						
ТУЗ-ийн гишүүд нь ТУЗ-ийн хурлын мэдээллийг цаг тухай бүрд нь и-мэйлээр хүлээн авч, биечлэн оролцох боломжгүй тохиолдолд саналаа цахим шуудангаар урьдчилан илгээдэг. Ийм тохиолдол цөөн бөгөөд хурлын ирцийг оролцсоноор тооцдог.						
ТУЗ-ийн гишүүний нэр	ТУЗ-ийн хорооны харьяалал			ТУЗ-ийн хурлын ирц	ТУЗ-ийн Хорооны ирц	
Т.Болд	Нэр дэвшүүлэх хорооны дарга			100%	100%	
	Аудитын хорооны гишүүн					
Ч.Нямдорж	Аудитын хорооны дарга			100%	100%	
Ж.Эрдэнэбат	Цалин урамшууллын хорооны дарга			100%	100%	
Б.Баянжаргал	Цалин урамшууллын хорооны гишүүн			100%	100%	
Б.Баттүшиг	Цалин урамшууллын хорооны гишүүн			100%	100%	
Д.Гансүх	Цалин урамшууллын хорооны гишүүн			100%	100%	
Б.Анхболд	Аудитын хорооны гишүүн			100%	100%	
А.Энхмэнд	Нэр дэвшүүлэх хорооны гишүүн			100%	100%	
Ц.Мөнхлхагва	Нэр дэвшүүлэх хорооны гишүүн			100%	100%	
Компани нь сайн засаглалын туршлагуудаас суралцах, хэрэгжүүлэх, мэдээллийн нээлттэй ил тод байдлын зарчмыг баримтлан хувьцаа эзэмшигчдээ шаардлагатай мэдээллээр ханган, санал хүсэлт, асуултад тухай бүр хариу өгч байгаа. Энэхүү зарчмын хүрээнд 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гаргах шийдвэрийн төсөл, түүнтэй холбоотой баримт бичиг бүхий тараах материалыг 2025.03.05-ны өдрийн дотор үнэт цаасны брокер, дилерийн компаниудад цахимаар хүргүүлсэн.						

	ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлж, гүйцэтгэх удирдлагын багийг удирдан ажилладаг. Тайлант хугацаанд компанийн гүйцэтгэх удирдлагын багийн бүрэлдэхүүн: - Гүйцэтгэх захирал Б.Баттүшиг Булигаар ХК-д ажиллаж буй хугацаа: 6 жил Булигаар ХК-ийн хувьцааны эзэмшил: 0.002% - Ерөнхий нягтлан бодогч Г.Сэлэнгэ Булигаар ХК-д ажиллаж буй хугацаа: 7 сар Булигаар ХК-ийн хувьцааны эзэмшил: Хувьцаа эзэмшдэггүй.																																																																															
7.	Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл																																																																															
	КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСЫН ХЭРЭГЖИЛТ Компани нь Санхүүгийн зохицуулах хорооны 2022.03.23-ны өдрийн 145 тоот тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ыг үйл ажиллагаандаа даган мөрдөж, 2024 оны жилийн эцсийн байдлаар 91.7%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажилласан байна. Энэ нь 2023 оны жилийн эцсийн үнэлгээнээс 34.8%-иар өссөн үзүүлэлт байна. 2023 оны жилийн эцсийн үнэлгээгээр Монгол улс дахь нээлттэй хувьцаат компаниудын 49-д эрэмбэлэгдэж байсан бол 2024 оны жилийн эцсээр Компанийн засаглалын үнэлгээгээр тэргүүлэгч топ 20 компаниудын эгнээнд багтаж, 6-р байранд орлоо. Түүнчлэн “Компанийн засаглалын кодекс” нь тасралтгүй хэрэгжиж, үйл ажиллагааны онцлогоос хамаарч үнэлгээ нь тухай бүр шинэчлэгддэг онцлогтой тул компанийн зүгээс 100%-ийн гүйцэтгэлээ хангахын тулд хүчин зүтгэлээ гарган ажиллах болно. <table border="1"> <thead> <tr> <th rowspan="2">№</th><th rowspan="2">Гарчиг</th><th rowspan="2">Авбал зохих нийт оноо</th><th colspan="2">2023.12.31</th><th colspan="2">2024.12.31</th></tr> <tr> <th>СЗХ-ны хяналтын оноо</th><th>Үнэлгээн ний хувь</th><th>СЗХ-ны хяналтын оноо</th><th>Үнэлгээн ний хувь</th></tr> </thead> <tbody> <tr> <td>1.</td><td>ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт</td><td>12</td><td>6</td><td>50%</td><td>12</td><td>100%</td></tr> <tr> <td>2.</td><td>ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг</td><td>10</td><td>7</td><td>70%</td><td>10</td><td>100%</td></tr> <tr> <td>3.</td><td>Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал</td><td>6</td><td>2</td><td>33.3%</td><td>4</td><td>66.7%</td></tr> <tr> <td>4.</td><td>Аудит, хяналтын тогтолцоо</td><td>6</td><td>4</td><td>66.7%</td><td>5</td><td>83.3%</td></tr> <tr> <td>5.</td><td>Эрсдэлийн удирдлага</td><td>8</td><td>6</td><td>75%</td><td>8</td><td>100%</td></tr> <tr> <td>6.</td><td>Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал</td><td>6</td><td>4</td><td>66.7%</td><td>6</td><td>100%</td></tr> <tr> <td>7.</td><td>Оролцогч талуудын эрх ашиг</td><td>8</td><td>2</td><td>25%</td><td>6</td><td>75%</td></tr> <tr> <td>8.</td><td>Компанийн соёл</td><td>6</td><td>6</td><td>100%</td><td>6</td><td>100%</td></tr> <tr> <td>9.</td><td>Хувьцаа эзэмшигчдийн эрх</td><td>10</td><td>4</td><td>40%</td><td>9</td><td>90%</td></tr> </tbody> </table>						№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	2023.12.31		2024.12.31		СЗХ-ны хяналтын оноо	Үнэлгээн ний хувь	СЗХ-ны хяналтын оноо	Үнэлгээн ний хувь	1.	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	6	50%	12	100%	2.	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	7	70%	10	100%	3.	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	2	33.3%	4	66.7%	4.	Аудит, хяналтын тогтолцоо	6	4	66.7%	5	83.3%	5.	Эрсдэлийн удирдлага	8	6	75%	8	100%	6.	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	4	66.7%	6	100%	7.	Оролцогч талуудын эрх ашиг	8	2	25%	6	75%	8.	Компанийн соёл	6	6	100%	6	100%	9.	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	4	40%	9	90%
№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	2023.12.31		2024.12.31																																																																											
			СЗХ-ны хяналтын оноо	Үнэлгээн ний хувь	СЗХ-ны хяналтын оноо	Үнэлгээн ний хувь																																																																										
1.	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	6	50%	12	100%																																																																										
2.	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	7	70%	10	100%																																																																										
3.	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	2	33.3%	4	66.7%																																																																										
4.	Аудит, хяналтын тогтолцоо	6	4	66.7%	5	83.3%																																																																										
5.	Эрсдэлийн удирдлага	8	6	75%	8	100%																																																																										
6.	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	4	66.7%	6	100%																																																																										
7.	Оролцогч талуудын эрх ашиг	8	2	25%	6	75%																																																																										
8.	Компанийн соёл	6	6	100%	6	100%																																																																										
9.	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	4	40%	9	90%																																																																										

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛ

Эхний улирлын байдлаар дараах тайлан мэдээллийг хуулийн хугацаанд СЗХ болон МХБ руу тус тус илгээн, олон нийтэд тайлагнан ажилласан.

- 2024 оны ашигт ажиллагаанаас ногдол ашиг тараах эсэх тухай тогтоол
- 2024 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан
- 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан
- 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт;
- 2024 оны компанийн Засаглалын кодексын хэрэгжилтийн тайлан
- 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах болсон тухай мэдэгдэл
- ТУЗ-ийн хурлаас гарсан тогтоол, шийдвэрүүдийг www.mse.mn сайтад байршуулсан.

НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Тайлант хугацаанд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлт гараагүй болно. Булигаар ХК нь нийт хувьцаа эзэмшигчийн тоо 2025.03.17-ны өдрийн байдлаар 400,212,000 хувьцааг 876 хувьцаа эзэмшигчидтэй байна.

Нийт хувьцаа эзэмшигчдээс 5 ба түүнээс дээш хувийг 3 хувьцаа эзэмшигч буюу 88.11%-ийг дараах нэр бүхий хувьцаа эзэмшигчид нь эзэмшдэг болно. Үүнд:

<i>Нэр</i>	<i>Тоо ширхэг</i>	<i>Хувь</i>
А.Энхмэнд	156,630,000	39.14%
Б.Анхболд	145,996,000	36.48%
Б.Баянжаргал	50,000,000	12.49%
Бусад 876 хувьцаа эзэмшигч	47,586,000	11.89%
Нийт дүн	400,212,000	

НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ


Булигаар ХК-ийн ТУЗ-ийн 2025.02.17-ны өдрийн №03/25 тоот тогтоолын дагуу компанийн 2024 оны санхүүгийн жилийн ашигт ажиллагаа зорилтод түвшинд хүрээгүй, Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадварт нөлөөлж болзошгүй тул Булигаар ХК-ийн ногдол ашгийн бодлогын 2.2. дахь хэсгийн 2.2.1. дэх заалтыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ

“Булигаар” ХК нь оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах үйл ажиллагааг идэвхжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд компанийн үйл ажиллагаатай биечлэн танилцах хүсэлтэй оролцогч талуудын хүсэлтийг хүлээн авч үйлдвэрийн онцлог, компанийн үйл ажиллагааг нээлттэй танилцуулдаг байгаа.

“ОРОЛЦОГЧ ТАЛУУДТАЙ ХАРИЛЦАХ, ХАМТРАН АЖИЛЛАХ БОДЛОГО, ХӨТӨЛБӨР”-ИЙН ХҮРЭЭНД МОНГОЛЫН АРИЛЖААНЫ БАНКНУУДЫН ТӨЛӨӨЛЛИЙГ ХҮЛЭЭН АВЧ, ҮЙЛ АЖИЛЛАГАА ТАНИЛЦУУЛАВ.

Тайлант хугацаанд Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж буй арилжааны 10 банкны төлөөлөл бүхий 50 хүн, Зээлийн батлан даалтын сангийн 20 хүнийг хүлээн авч хүрээнд компанийн үйл ажиллагаатай биечлэн нээлттэй танилцуулах ажлыг зохион байгуулсан.



8

Үйл ажиллагаатай холбоотой бусад нэмэлт мэдээлэл

**БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛСАД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН
“МОНГОЛ-ТУРКИЙН БИЗНЕС ФОРУМ-Д АЖИЛТТАЙ ОРОЛЦОВ.**

1. БНТУ-ын Анкара, Истанбул хотуудад Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхимын зохион байгуулсан Монголын аж ахуй нэгжүүд, бизнесийн төлөөллийн гадаад харилцаа, түншлэл, хамтын ажиллагааны цар хүрээг тэлэх, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлан таниулах, гадаад хөрөнгө оруулалтыг татах зорилго бүхий “Монгол-Туркийн бизнес форум”-д Булигаар ХК-ийн төлөөлөл амжилттай оролцлоо.



Тус Бизнес Форумын үеэр БНТУ-ын “Бурса” аж үйлдвэрийн паркийн арьс шир боловсруулах үйлдвэрийн бүсийн үйл ажиллагаа болон үйлдвэрлэлээс гарч буй бохир усыг хэрхэн байгальд ээлтэйгээр цэвэршүүлэх “Цэвэрлэх байгууламж”-ын технологи ажиллагаатай танилцан, мөн БНТУ-ын “Гэрэдэ” аж үйлдвэрийн паркийн арьс ширний боловсруулах үйлдвэрүүдийн паркийн менежмент, хүний нөөц, мэргэжилтэн бэлтгэх, туршлага судлах, цэвэрлэх байгууламж, хог хаягдлын менежментийн чиглэлээр үйл ажиллагаатай нь танилцан туршлага судлан ажиллалаа.

УСНЫ ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ

- Уурын конденсац үүссэн хаягдал усыг тусгай зориулалтын танканд хүлээн авч тоног төхөөрөмж угаах, цехийн цэвэрлэгээ үйлчилгээ, арьс боловсруулах анхан шатны тордолгоонд хэрэглэж байна.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ

- “Эрчим хүч хэмнэлтийн тухай” хуулийн үүргээ биелүүлэн 2024 оны эрчим хүч хэмнэлтийн тайлан, 2025 оны эрчим хүч хэмнэлтийн төлөвлөгөөг боловсруулж “Эрчим хүчний зохицуулах хороо”-д хүргүүлэв.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Г.Сэлэнгэ

Албан тушаал: Ерөнхий нягтлан бодогч

Гарын үсэг: *Г. Сэлэнгэ*

Овог, нэр: Ц.Мөнхлхагва

Албан тушаал: ТУЗ-ийн гишүүн

Гарын үсэг: *Ц. Мөнхлхагва*